

**“СҮХБААТАР” НЭГДСЭН ЭМНЭЛЭГ
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

2025.12.01

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв / төгрөг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2024 он	Зорилтот түвшин 2025 он	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1 НЭГ.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД / Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулан, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна. /МУХТЖТ-2.2.2, 2.2.8, МУХТЖҮЧ-2.2.1, НХТЖҮЧ-2.5, 2.6, 2.7, 2.9.1, 2.9.2, 2.11.1, НЗДҮАХ- 2.1, НХЖТ-2.1/							
1	1.1 Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоог зохион байгуулах	5,000.0	Эрт илрүүлгийн чиглэл	-	1-2	Эрт илрүүлгийн чиглэл – 3 Шинээр илэрсэн өвчлөлийн түвшин – 28,2% Сүхбаатар дүүргийн иргэдийг хүн ам, нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ оношилгоонд оруулах ажлыг эрчимтэй зохион байгуулж байна. 2025 оны эхний 11 сарын 14-ний байдлаар 45965 хүнийг үзлэг оношилгоонд хамруулсан. Үүнээс:	100%

			Шинээр илэрсэн өвчлөлийн хувь	-	5%	<ul style="list-style-type: none"> • 50 Цэцэрлэг, 10 Сургуулийн нийт 31869 хүнийг үзлэгт хамруулсан, үүнээс: 30359 хүүхэд, 1560 багш ажилчид • Ахмадын үзлэгт - 380 хүн, • Байгууллага – 9 нийт 395 ажилтан • Амбулаторийн үзлэг оношилгоо шинжилгээнд 13326 хүнийг 2025 эхний 11 сарын 14-ний байдлаар хамруулаад байна. <p>Үзлэг, оношилгооны дүгнэлтээс үзвэл амьсгалын замын халдвар 32%, даралт ихсэлт 22%, хоол боловсруулах эрхний эмгэг 35%, бөөр шээс ялгаруулах эрхтний эмгэг 24 % илэрсэн байна.</p>	
2	1.2 Ахмад настны үзлэгийг зохион байгуулах	5,000.0	Эрсдэлт бүлгийн ахмад настанг үзлэгт хамруулсан тоо	-	300	<p>Хамрагдсан ахмад настан – 368 Эмчилгээнд хамрагдсан – 32 хувь ЭМС-ын 2025 оны 01 сарын 31-ний өдрийн А/128 тоот “Үзлэг зохион байгуулах тухай” тушаалыг үндэслэн “Сүхбаатар” нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны 02 сарын 07-ны өдрийн А/23 тоот “Ахмад настны үзлэг зохион байгуулах тухай” тушаал гарсан.</p> <p>Үүний дагуу “Ахмадын настны үзлэг зохион байгуулах ажлын удирдамж, ахмад настны үзлэгт ажиллах эмч ажилтны баг гарган ажиллуулсан.</p> <p>Ахмад настны үзлэгийг 7 хоногийн Баасан гаригт бүр нийт 6 удаа зохион байгуулж, Сүхбаатар дүүргийн 1-10 хорооны 368 ахмад настан хамрагдсан байна.</p> <p>Үзлэгт нийт 34 эмч сувилагч нарын бүрэлдэхүүнтэй, 15 төрөлжсөн мэргэжлийн эмч нар үзлэг хийж, цус, шээс, биохимийн дэлгэрэнгүй шинжилгээнд хамруулж,</p> <ul style="list-style-type: none"> • Цээжний рентген зураг • Хэт авиан шинжилгээ • Зүрхний цахилгаан бичлэг, зүрхний хэт авиа • Ходоодны дуран зэрэг багажийн шинжилгээнд хамруулсан. 	100%
			Эмчилгээн Д хамрагдсан ахмадын тоо	-	25%	Хэвтүүлэн эмчлүүлэх шаардлагатай 100 гаруй ахмад настанг хуваарийн дагуу хүлээн авч хэвтүүлэн эмчилж байна.	

3	1.3 Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах	5,000.0	Арга хэмжээний тоо	11	12	<p>Сүхбаатар нэгдсэн эмнэлэгт ЭМС-ын тушаалаар болон бусад захирамжлалын баримт бичгээр баталсан дараах арга хэмжээнүүдийн хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <p>Арга хэмжээний тоо-13</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p>	100%	
			Хэрэгжилтийн хувь	100%	100 %			
			№	Арга хэмжээ, хөтөлбөрийн нэр	Зорилт, үйл ажиллагаа			Хэрэгжилтийн хувь
			1	Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ (2022-2025)	3 зорилт 4 үйл ажиллагаа			100
			2	Сэтгэцийн эрүүл мэнд арга хэмжээ (2024-2027)	1 зорилт 4 үйл ажиллагаа			100
			3	Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх арга хэмжээ (2024-2027)	3 зорилт 10 үйл ажиллагаа			100
			4	Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын арга хэмжээ (2024-2026)	7 үйл ажиллагаа			100
			5	Эрүүл настан, идэвхтэй насжилтыг дэмжих арга хэмжээ (2025-2028)	7 үйл ажиллагаа			100
			6	Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх салбар дундын үйл ажиллагааны төлөвлөгөө” (2022-2025)	5 үйл ажиллагаа			100
			7	Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх арга хэмжээ (2024-2027)	4 чиглэлээр 32 үйл ажиллагаа			100
8	Эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч	1 үйл ажиллагаа	100					


						хэрэгжүүлэх арга хэмжээ (2024-2027)					
						9 Хорт хавдраас сэргийлэх, хянах хөтөлбөр (2025-2028)	4 зорилт 5 үйл ажиллагаа	100			
						10 “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээ	3 зорилт 4 үйл ажиллагаа	100			
						11 Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд	8 үйл ажиллагаа	100			
						12 Өсвөр үеийн тусламж үйлчилгээ	19 үйл ажиллагаа	100			
						13 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах ажлын удирдамж, хэрэгжүүлэх төлөвлөгөө /2022-2025/ ЭМС-ын 2022 оны А/136 тушаал	25 үйл ажиллагаа	100			
4	1.4 Гамшгийн үед хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээг шуурхай зохион байгуулж тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах	5,000.0	Арга хэмжээнд оролцсон тоо	2	2	Арга хэмжээний тоо-6 Хамрагдсан ажилтан- 704 1.Газар хөдлөлтийн аюулыг таниулах, өөрийгөө хамгаалах дадлага сургуулилт Сүхбаатар нэгдсэн эмнэлэг нь МУ-ын Засгийн газрын Гамшгийн аюулын тухай мэдээллийг зарлан мэдээлэх журмыг баталсан 339 тоот тогтоол, 2017 оны “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай” 67 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, 2025 оны 03 сарын 26-нд “Газар хөдлөлтийн аюулыг таниулах, өөрийгөө хамгаалах” сургалтыг 33 эмч мэргэжилтэнд таниулж, 2025 оны 03 сарын 27-ны өдрийн 16 цагт гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх эхний дохиогоор Сүхбаатар нэгдсэн эмнэлгийн бүрэлдэхүүн “Суу, нуугд, хүлээ” зарчмыг баримтлан, зарлан мэдээллийн 2 дахь дохиогоор “Гүйхгүй, Ярихгүй, Түлхэхгүй, Эргэж буцахгүй” зарчмаар эмнэлгийн байрнаас заагдсан гарцаар гарч, аюулгүй		Хамрагдсан ажилтны тоо	15	20	100%

					<p>талбайд цугларлаа. Нийт 156 ажилтан цугларч 3 дахь дохиогоор тасаг бүр бүртгэлээ хийж, гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх дохиогоор дадлага сургуулилтаа амжилттай хийж дуусгалаа.</p> <p>2. Улаанбаатар Марафон – 2025</p> <p>НЭМГ-ын даргын 2025 оны 05 сарын 23 ны А/128 тушаал, Сүхбаатар нэгдсэн эмнэлгийн захирлын А/89 “Улаанбаатар Марафон – 2025” олон улсын гүйлтийн үеийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг зохицуулах тухай” тушаалын дагуу 2025 оны 05 сарын 24-нд СБНЭ-ийн баг 6 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан. Нийт 21 хүнд яаралтай эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн.</p> <p>3. Улаан бурхан өвчний халдварын дэгдэлтийн үеийн үйл ажиллагаа</p> <p>Улаан бурхан өвчний халдварын тархалт нэмэгдсэн 2025 оны 02 сараас 07 сар хүртлэх хугацаанд Нэгдсэн эмнэлгийн шуурхай удирдлагын баг захирлын тушаалаар томилгоожиж, төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа идэвхжүүлсэн. Захирлын А/102 тушаалаар өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллав. Эмч, эмнэлгийн ажилчдыг улаан бурханы эсрэг вакцинаар дархлаажуулах, үйлчлүүлэгч болон ажилчдын дунд хам шинжийн тандалт хийх, халдварын сэжигтэй үйлчлүүлэгчдийг тусгаарлах, сорьц зөөвөрлөх, батлагдсан үйлчлүүлэгчдийг эмнэлэг хооронд шилжүүлэх, халдваргүйтгэл хийх, эмч ажилчдад сургалт орох, үйлчлүүлэгчдэд улаан бурхан өвчнөөс сэргийлэх, дархлаажуулалтын ач холбогдлын тухай сургалт сурталчилгаа хийх ажлуудыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэв. Улаан бурханы дархлаажуулалтад нийт 143 ажилтан хамрагдсан байна.</p>	
--	--	--	--	--	--	--

						<p>4. ЭМС-ын 2025 оны 06 сарын 24-ний өдрийн “Эрүүл мэндийн салбарыг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай “ А/249 тушаалын дагуу өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллалаа.</p> <p>5. НЭМГ-ын даргын 2025 оны 08 дугаар сарын 20 ны өдрийн А/259 дугаар “Тогтолцооны удирдлагын тогтолцоогоор ажиллах тухай” тушаалын дагуу үер усны гамшгаас сэргийлэх, гэдэсний халдвараас сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллав.</p> <p>6. 2025.11.06-нд Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн Үндэсний төвийн 30 жилийн ойг тохиолдуулан зохион байгуулагдсан “Түгээмэл тохиолддог эм, химийн хордлогын үеийн оношилгоо, эмчилгээ яаралтай тусламж” сэдэвт сургалтанд хамрагдлаа. Сургалтанд хамрагдсан эмч нар нийт эмч нарт мэдээллийг хүргэв.</p>	
5	1.5 Томуугийн тархалтын түвшингийн үе шат бүрт тохирсон хариу арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	5,000.0	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	96%	96%	<p>Төлөвлөгөөний хэрэгжилт-100%</p> <p>2024-2025 оны томуугийн улиралд Нэгдсэн эмнэлгийн даргын 2024 оны А/154 тоот "Томуу томуу төст өвчинтэй тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээ авах тухай тушаалаар "Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинд тохирсон бэлэн байдал, хариу арга хэмжээний төлөвлөгөөг баталж ажилласан.</p> <p>Сургалтанд эмч нарыг хамруулж, дайчлан ажиллах ажилчдын нэрсийг гаргасан. Хүүхдийн мэргэжлийн эмч, сувилагч нарыг ажилд авч хүний нөөцийг бүрдүүлэн ажиллав.</p> <p>2025 оны 01 сараас ЕБС-ийн сурагчдын амралт эхэлсэнтэй холбоотой ТТӨ-ний үеийн ачаалал багассаар 2025 оны 01 сараас хүүхдийн хэвтэлт хэвийн хэмжээнд байв. Менингококкийн халдвар, улаан бурханы халдвараас урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг ханган ажиллаж байна.</p>	100%

						<p>2025-2026 оны томуугийн улиралд Нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны А/144 тоот "Томуу томуу төст өвчинтэй тэмцэх, сэргийлэх хариу арга хэмжээ авах тухай тушаалаар "Томуу, томуу төст өвчний тархалтын түвшинд тохирсон бэлэн байдал, хариу ага хэмжээний төлөвлөгөөг баталж ажиллаж байна. Улирлын томуугийн дархлаажуулалтанд 220 эрүүл мэндийн ажилтан хамрагдсан хамрагдалт 88%-та байна.</p> <p>2025 оны 11 дүгээр сарын 22 ны өдрөөс ДМТасгийн орыг хүүхдийн оронд шилжүүлж зохицуулж ажиллаж байна. А/Н3N2/ томуугийн вирусын халдвар, ТТӨ-ий алаг цоог дэгдэлтийн түвшинд ор дэлгэх, хүүхдийн яаралтай тусламжийн нэгжийн эмч нарын тоог нэмэгдүүлж, нэмэлт жижүүр эмч томилох, эмнэлгийн мэргэжилтэнг ТТӨ-ий удирдамж, зааврын сургалтанд оролцуулах, халдвараас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх арга хэмжээг авч байна.</p>	
6	1.6 Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд ЭМБО сургалт хийх	3,000.0	Сургалтын сэдвийн тоо	27	15	<p>Сэдвийн тоо- 32</p> <p>Хэрэгжилтийн хувь-100</p> <p>Нийгмийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтуудыг зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр</p> <p>2025 оны 04 сарын 28-ны өдрөөс 05 сарын 05-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэв.</p> <p>Сүрьеэ өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эмчлэн сэргийлэх, нийгэм сэтгэл зүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, хүн амын дунд сүрьеэ өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажил хийх замаар эрүүл зан үйлийг төлөвшүүлэх зорилготой. Төлөвлөгөөний дагуу нийт 6 ажил хийж гүйцэтгэсэн.</p> <p>Хавдарын эсрэг дэлхийн өдөр мэдээлэл хийж, суртчилгааг пейж хуудсаараа түгээв.</p> <p>“Бөөр хамгаалах дэлхийн өдөр”-ийг 2025 оны 04 дүгээр сарын 10-17-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн. Бөөр хамгаалах дэлхийн өдөр”-ийн талаар СБНЭ-ийн эмнэлгийн мэргэжилтэнд сургалт явуулж мэдээлэл хүргэлээ.</p> <p>Дотор мэдрэлийн тасаг, хүүхдийн тасаг, эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгийн нийт 4</p>	100%
			Хэрэгжилтийн хувь	90%	90%		

байршилд 120 ширхэг сургалтын материал хэвлэн байршуулав. Яаралтай тусламжийн хүлээн авах, хүлээлгийн хэсэг, ДМТ тасагт байрлах зурагтаар богино хэмжээний бичлэг анимешнуудыг гаргав. 2 өдрийн турш ДМТ-д хэвтэн эмчлүүлж буй 176 үйлчлүүлэгч болон сахиурт сургалт явуулав.



Сүхбаатар нэгдсэн эмнэлэг нь 04 сарын 02-ны “Дэлхийн аутизмын өдөр”-тэй холбогдуулан эмнэлгийн мэргэжилтэнд сургалт зохион байгуулж, хэрхэн оношлох талаар анхан шатны мэдлэг олгосон. Нийт 119 эмч эмнэлгийн ажилчид хамрагдсан. НЭМГ-ын 2025 оны 04 сарын 11-ний өдрийн 01/877 тоот удирдамжийн дагуу “Сүхбаатар” нэгдсэн эмнэлгийн даргын 2025 оны 05 сарын 15-ны өдрийн А/83 тоот “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” аян зохион байгуулах тухай тушаал гарсан.

- Байгууллагын нийт 235 эмнэлгийн мэргэжилтэнд аяны удирдамж, төлөвлөгөөг танилцуулж, тасгийн эмч ажилчид “Өсвөр үеийнхнийг сонсьё, ойлгоё” сэдэвт аянд нэгдэж, эмчлэгдэж буй өсвөр насны хүүхэд, асран хамгаалагч нарт сургалт явуулсан
- Эмнэлгийн page хуудсаар “Тамхинаас гарцгаая” электрон тамхины хор уршиг, нөлөөллийн талаар эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч Б.Дугар мэдээлэл өгсөн.
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн бойжилтын талаар сургалтын материал бэлдэж, доорхи

					<p>сэдвүүдээр ЭМБО сургалтыг ерөнхий боловсролын 84, 57-р сургуулийн нийт 95 хүүхдэд чанарын менежер Э.Отгонбумба явуулсан.</p> <ul style="list-style-type: none"> • “Харилцаа” • “Хүйс ба жендэр” • “Бэлгийн боловсрол” сэдвүүдээр хийсэн <p>“Өсвөр үеийнхний хорт бодисын хэрэглээ” сэдвээр нийт 386 тараах материал бэлдэж хүүхдийн тасаг, яаралтай тусламжийн тасагт байрлуулж, өсвөр насны хүүхдүүд болон асран хамгаалагч нарт тараасан.</p> <p>“Дэлхийн тамхины эсрэг өдөр”-ийг 2025 онд “Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилъе!” уриан дор тэмдэглэж байна. Энэхүү уриа нь тамхи, никотины үйлдвэрлэлүүдийн залуучуудыг татах зорилгоор ашигладаг сэтгэл татам амт, өнгөлөг сав баглаа боодол, дижитал сурталчилгаа зэрэг арга тактикуудыг илчлэхэд чиглэж байна.</p> <p>2025 оны 05 сарын 30-нд “Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилъе!” уриан дор СБНЭ-Дотор Мэдрэлийн тасаг-т хэвтэн эмчлүүлж байгаа 52 үйлчлүүлэгчдэд сургалт хийлээ.</p> <div style="display: flex; justify-content: space-around;">   </div> <p>“Сүхбаатар” Нэгдсэн эмнэлэг нь “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр”-ийг “Үйлчлүүлэгчийн дуу хоолойг сонсьё” уриан дор доорхи ажлуудыг зохион байгуулсан.</p> <p>Эрүүл мэндийн боловсрол олгох сургалт – Дотор мэдрэлийн тасаг - Аяны хугацаанд нийт 8 сэдвээр тараах материал 118 ширхэгийг бэлтгэж сургалтанд ашиглаж байна. Тасгийн гурван сувилагч дараах гурван сэдвээр видео сургалт бэлтгэж, тасгийн үйлчлүүлэгчдэд сургалт явуулж байна. 80 үйлчлүүлэгч хамрагдсан.</p>
--	--	--	--	--	---

					<p>Хүүхдийн тасаг - “Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр”- ийг тохиолдуулан Хүүхдийн тасагт эмчлэгдэж байгаа үйлчлүүлэгчид болон асран хамгаалагчдад нээлттэй өдөрлөг зохион байгуулав. Өдөрлөгөөр нийт 120 үйлчлүүлэгч болон сахиуруудад хүчилтөрөгчийн коктейл болон амны хаалт тарааж , тасгийн үйл ажиллагааны онцлог танилцуулан, “Томуу томуу төст өвчин” тухай 5 сэдвээр сургалт зохион байгуулж үйлчлүүлэгдээс аман болон бичгэн хэлбэрээр сэтгэгдэл сонсож найрсаг орчин бүрдүүлж ажиллалаа. Мэс заслын тасаг-Хэвтэх үед бүрдүүлэх шинжилгээний талаар зөвлөгөө өгөх, хагалгааны өмнөх өдөр хагалгаанд хэрэглэгдэх зүйлс,хагалгааны өмнөх бэлтгэл болон хооллолт, нойрны талаар зөвлөгөө өгдөг./5/ Хэвтэн эмчлүүлж буй бүх үйлчлүүлэгчдэд хагалгааны дараах хооллолт, хөдөлгөөн, шарх , гуурс арчилгаа, гарын ариун цэвэр, боолтны талаар зөвлөгөө өгч сургалт хийдэг.</p> <p>Эрчимт эмчилгээ яаралтай тусламж - Яаралтай тусламжийн хүлээлгийн хэсэгт тараах материал, постерыг байршуулж, видео сургалтыг тогтмол явуулж, ЭМБОСургалтыг тасралтгүй 24 цагаар хийж байна. Эрчимт эмчилгээний Сахиурын өрөөнд “Сувилагчийн мэдээлэл” самбар ажиллуулж ар гэр, сахиуруудад хэвтрийн өвчтөний асаргаа сувилгаа, мэдээлэл, зөвлөмжүүдийг хүргэж байна. Эрчимт эмчилгээний сувилагч нар хэвтэн эмчлүүлэгчдэд, сахиуруудад сургалтыг сургалт сурталчилгааны материал ашиглан тогтмол хийж байна. Аяны хугацаанд 80 хүнд сургалт хийсэн байна. /5 сэдэв/</p>	
--	--	--	--	--	---	--



Нийт 23 сэдэв

Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр

2025.11.13-нд хурлын зааланд ДТТасгийн хамт олон өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгөөр чихрийн шижингийн эрсдлийн үнэлгээ, артерийн даралт ихдэлтийн эрсдлийн үнэлгээ хийж дотоод шүүрэл, хоол зүйч, нүдний эмч, бөөрний эмч нар үзлэг хийж, зөвлөгөө өгсөн. Нийт 30 хүн хамрагдснаас 1 хүн диабет шинээр оношлогдож, 3 хүн санамсаргүй сахарын өөрчлөлттэй, 6 хүн бодисын солилцооны алдагдал оношлогдсон. Тус аяны хүрээнд ДМТ нь Диабетийн хүндрэлүүдийн талаар таниулах брошур материал бэлдэж урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан иргэдэд тарааж эрүүл мэндийн боловсрол олгох сургалтанд хамруулсан.





“Уушгины архаг бөглөрөлт өвчинтэй тэмцэх өдөр”
2025.11.18 нд Дотор мэдрэлийн тасгийн уушгины эмч нь нийт эмч мэргэжилтэнгүүдэд ““Амьсгаа давхцаж байвал уушгины архаг бөглөрөлт өвчнийг бод” уриан дор УАБӨ-тэй тэмцэх дэлхийн өдрийн хүрээнд уушгины архаг бөглөрөлт өвчний 2025 онд шинэчлэгдсэн GOLD удирдамжийн нэмэлт мэдээлэл болон өөрчлөлтийн талаар танилцуулав.

ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр

12-р сарын 01-ны өдрийг ДОХ-той тэмцэх дэлхийн өдөр болгон тэмдэглэдэг бөгөөд энэ жил “Overcoming disruption, transforming the AIDS response” “Асуудал саад бэрхшээлүүдийг давсанаар, ДОХ-ын хариу арга хэмжээг өөрчлөнө” уриан дор Сүхбаатар Нэгдсэн Эмнэлгийн ХСХАлба болон Поликлиникийн тасаг хамтран зохион байгуулж, тэмдэглэн өнгөрөөлөө.

Уг өдрийн хүрээнд нийт тусламж үйлчилгээ үзүүлж буй эмч, эмнэлгийн ажилчид “Улаан тууз” зүүж тасгийн ажилтнуудад мэдээлэл хүргэж, хүлээн авах хэсэгт видео мэдээлэл байршуулан, хүлээн авах, эргэлт болон амбулаторийн тусламж үйлчилгээ авч буй, хэвтэн эмчлүүлж буй иргэдэд гарын авлага /брошур/ тарааж уг өдрийн талаар болон бусад БЗДХ өвчнүүд гэх мэт нийт 3 төрлийн мэдээлэл хүргэж ажиллаа.

Мөн эмч, сувилагч, асрагч нарт ДОХ-той тэмцэх өдрийн талаар болон ХДХВ-н шинж тэмдгүүд, урьчилан сэргийлэлт, эмчилгээ зэргийн мэдээллийг project хэлбэрээр нийт 120 ажилтанг сургалтанд хамруулсан.

7	1.7 Эрүүл зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн сургалт, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх	500,0	Сургалтын сэдвийн тоо арга хэмжээний тайлан	12	12	<p>Аян-4, арга хэмжээ-10 нийт 14 Тайлан хэрэгжилтийн хувь- 100% “Маскаа зүүцгээе” аянд нэгдэж хүүхдийн тасаг аяныг зохион байгуулж, нийт эрүүл мэндийн ажилтан, хэвтэн эмчлүүлэгч, сахиур, эргэлт болон хүлээн авах тасаг, амбулаториор үйлчлүүлэгчдэд сургалт, сурталчилгаа явуулж байна.</p> <p>Байгууллагын page хуудсанд санамж, зөвлөмжүүдийг байрлуулсан.</p> <p>СБНЭ-ийн даргын 2025.03.03-ны өдрийн “Нийслэлийн Эрүүл мэндийн газрын нэрэмжит “Шилжин явах цом”-ын төлөөх тэмцээнд оролцох тухай” тушаалаар баг тамирчдыг бэлдэн оролцсон. Ширээний теннис болон дартсад мөн баг тамирчид ажилттай оролцсон. Нэгдсэн эмнэлгийн сагсан бөмбөг болон Дота-2 төрөлд тус тус мөнгөн медаль авсан.</p> <p>2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 03 сарын 30-ны өдрүүдэд зохиогдсон Эрүүл мэндийн сайдын нэрэмжит спортын арга хэмжээнд 2 баг (сагсан бөмбөгийн эрэгтэй тамирчид, “Дота”e-spots баг) тамирчдыг бэлтгэн оролцуулсан. “Дота” e-spots баг 2-р байр эзэлсэн</p> <p>НЭМГ-ын 2025 оны 04 сарын 15-ны өдрийн 883 тоот “Хэрэгжилтийг ханган ажиллах тухай” зөвлөмжийн дагуу угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх талаар доорхи ажлыг хийсэн:</p> <p>“Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, хордлогод өртсөн тохиолдолд авах хэмжээ” сэдвийн дагуу төлөвлөгөө гарч байгууллагын даргаар батлуулан 100% хэрэгжүүлсэн.</p> <p>“Хүнсний харшлыг сэрэмжлүүлэх 7 хоног”-ийг 2024 оны 05 дугаар сарын 11-17-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэв. Хүнсний харшлын сэрэмжлүүлгийг хүргэх, хүнсний харшлын талаарх буруу ойлголтыг залруулж, зөв мэдээлэл үйлчлүүлэгч, эмнэлгийн ажилтанд түгээх мэдлэг олгох 7 хоногийг тэмдэглэн өнгөрүүлж, эрүүл мэндийн боловсрол олгох сургалт хийв.</p> <p>“Дэлхийн тамхины эсрэг өдөр” “Эхийн сүүгээр хооллох дэлхийн өдөр”</p>	100%
			Хэрэгжилтийн хувь	92%	93%		

“Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр”- ийг тохиолдуулан Хүүхдийн тасагт эмчлэгдэж байгаа үйлчлүүлэгчид болон асран хамгаалагчдад нээлттэй өдөрлөг зохион байгуулав.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн эерэг соёлыг хамтдаа төлөвшүүлье” аян
ХАБЭА-н талаарх хууль, журам, дүрэм, стандартыг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, сурталчилах арга хэмжээг сарын аяны үеэр өргөн зохион байгуулах нь эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, ажилчид үйлдвэрлэлийн осолд өртөхгүй байх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлийг бууруулахад зохих хувь нэмрээ оруулах зорилгоор аян зохион явуулсан. Төлөвлөгөөний дагуу 12 ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Эмийн аюулгүй байдлын долоо хоног-2025” аян
“Бичил биетний тэсвэржилтийн эсрэг мэдлэг хандлагыг дээшлүүлэх дэлхийн 7 хоног”
“Гар угаах дэлхийн өдөр” арга хэмжээ
Чихрийн шижинтэй тэмцэх дэлхийн өдөр
Нэгдсэн эмнэлгийн спортын арга хэмжээ-2025 оны 11 сарын 15-16-нд амжилттай зохион байгуулагдаж, 7 тасгийн эрэгтэй, эмэгтэй багууд өрсөлдөж эрэгтэй, эмэгтэй сагсан бөмбөг, гар бөмбөгөөр аварга багийг тодруулж шилжин явах цом, 80 медаль гардуулсан байна. Спортын арга хэмжээ ёс зүй, сахилга хариуцлагын хувьд өндөр түвшинд зохион байгуулагдаж багаар ажиллах, чадварыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгсөн.

